**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АЛБА**

Огноо: 2020 оны 01 сарын 23

# ХАН-УУЛ ДҮҮРЭГТ ШИНЭЭР БАЙГУУЛАГДСАН ХОРООДЫН ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВД ШААРДЛАГАТАЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ХУДАЛДАН АВАХ ГҮЙЦЭТГЭГЧ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

**Төслийн нэр:** Хан-Уул дүүрэгт шинээр байгуулагдсан хороодын Өрхийн эрүүл мэндийн төвд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах

**Төслийн дугаар:** ХУД2020/ДТХ-04-20

**Улаанбаатар хот**

**2020 он**

## ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: ***2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр***

***Хан-Уул дүүргийн Худалдан авах ажиллагааны алба*** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос ***Хан-Уул дүүрэгт шинээр байгуулагдсан хороодын Өрхийн эрүүл мэндийн төвд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах, ХУД2020/ДТХ-04-20*** дугаартай тендерт үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Борлуулалтын хэмжээ:
  - ***Сүүлийн 2 жилд /2018, 2019 он/ гүйцэтгэсэн борлуулалтын орлого аль нэг жилд 30,000,000 төгрөгөөс багагүй байна.***
- Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:
  - ***Сүүлийн 2 жилийн /2018, 2019 он/ аль нэг жилийн хугацаанд дор хаяж нэг удаа 30,000,000 төгрөгөөс багагүй үнийн дүнтэй эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж нийлүүлсэн байна.***
- Тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх. Үүнд:
  - ***Эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж импортлох, ханган нийлүүлэх, худалдах***

Үнийн саналыг ***2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 10.00 цаг***-аас өмнө ***цахим системээр*** илгээнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан ***2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 10.30 минут*** -т нээнэ.

Дотоодны давуу эрх тооцох эсэх: ***тооцохгүй***

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно. Цахим худалдан авах систем (www.tender.gov.mn)-ээс үнэ төлбөргүй татаж авна уу.

***Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө, Иргэдэд үйлчлэх төв байр, 9 давхарт 902 тоот,***
***утас: 70009011***

## Хоёр. **ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА**

| | | |
|---|---|---|
| **1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа** | 1.1. | Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| **2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт** | 2.1. | Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна. |
| | 2.2. | Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ. |
| | 2.3. | Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| **3. Тендерийн иж бүрдэл** | 3.1. | Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:<br>(а) Үнийн санал;<br>(б) Барааны үнэ, бараа нийлүүлэлтийн хуваарь; /гарын үсэг зурж баталгаажуулах/<br>(в) Чадварын мэдээлэл /туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, / болон бусад баримт бичиг;<br>(г) Техникийн тодорхойлолт /барааны үзүүлэлт, стандарт/<br>(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| **4. Тогтмол үнэ** | 4.1. | Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| **5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд** | 5.1. | Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана. |
| | 5.2. | Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| **6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа** | 6.1. | Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |

| | | | |
|---|---|---|---|
| **7.** | **Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх** | 7.1. | Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ. |
| | | 7.2. | Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ***ТШӨХ-д*** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ. |
| | | 7.3. | Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |
| **8.** | **Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл** | 8.1. | Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна. |

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

| **ТӨЗ-ны холбогдох заалт** | **Шалгуур үзүүлэлт** |
|---|---|
| **ТӨЗ 1.1** | Захиалагч нь:***Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар*** |
| | Тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар**:** ***Хан-Уул дүүрэгт шинээр байгуулагдсан хороодын Өрхийн эрүүл мэндийн төвд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах***<br>*Тендер шалгаруулалтын дугаар:* ***ХУД2020/ДТХ-04-20*** |
| **ТӨЗ 1.1 (а)** | Тендерт оролцогч эрх бүхий эсэхийг дараах бичиг баримтаар нотолж ирүүлнэ:<br>- ***Тендерт оролцогч "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 14.1-д заасан нөхцөл байхгүйг бичгээр мэдээлнэ.*** */албан бланкан дээр баталгаажуулж ирүүлнэ/*<br>- *Хуулийн этгээдийн бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хаягийг тодорхойлсон* ***Улсын бүртгэлийн гэрчилгээ-****г эх хувиас сканердах эсвэл хуулбарыг нотариатаар баталгаажуулж ирүүлнэ.*<br>- ***Тендерт гарын үсэг зурах этгээдийн гарын үсгийн баталгааг бичгээр гаргах түүний итгэмжлэл МАЯГТ № ТШМ 2-3 -ын дагуу албан бланкан дээр баталгаажуулж ирүүлнэ/***<br>- ***Тендерт оролцогч нь тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагагүй бөгөөд Улсын бүртгэлийн гэрчилгээнд гадаад худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байх.***<br>- ***Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар,хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Тендерт оролцогч татварын тодорхойлолтыг ирүүлэх шаардлагагүй ба [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) сайтаас нээлт болсон өдрөөр татварын тодорхойлолтыг захиалагч татан авч үзнэ.***<br>- ***Харьяа Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт***<br>- ***Харилцагч банкны тодорхойлолт*** */өр зээлтэй эсэх/*<br>- ***Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт***<br>- ***Тендерт оролцогчийн ирүүлсэн үнийн санал, тендерийн үр дүнг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл ирүүлнэ.***<br>- ***Тухайн барааны үйлдвэрлэгчийн гаргасан техникийн тодорхойлолт, нийлүүлэх барааны зураг, үйлдвэрлэгчийн каталогийг ирүүлнэ****. (Каталоги дээрээс санал болгож буй барааг ялган тодруулж ирүүлэх)* ***Тендерийн материалыг цахим хэлбэр PDF-ээр ирүүлэхдээ харагдах хэлбэр нь сайн уншигдахаар тод гаргацтай бэлтгэж ирүүлнэ. /****Уншигдах боломжгүй шаардлага хангаагүй тендерийн материал нь тухайн тендерээс татгалзах үндэслэл болно./*<br>- |

<table>
<tr><td></td><td>
- Тендерийн материалыг цахим хэлбэр PDF-ээр ирүүлэхдээ харагдах хэлбэр нь сайн уншигдахаар тод гаргацтай бэлтгэж ирүүлнэ. /Уншигдах боломжгүй шаардлага хангаагүй тендерийн материал нь тухайн тендерээс татгалзах үндэслэл болно./<br><br>
- Бараа нийлүүлэх хуваарь /Захиалагч болон нийлүүлэгчийн техникийн тодорхойлолтыг харьцуулсан байдлаар хүснэгтээр бэлтгэж баталгаажуулан ирүүлнэ./<br><br>
Дээрх тодорхойлолтуудыг тендер зарлагдсан өдрөөс хойш авсан байна.<br><br>
Монгол улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлсөн эсэхийг тендер нээсэн өдрөөр тооцно.
</td></tr>
<tr><td>ТӨЗ 1.1 (б)</td><td>Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн буюу 2018, 2019 он<br><br>Борлуулалтын орлогын нийт мөнгөн дүнгийн жилийн дундаж нь: Сүүлийн 2 жилийн хугацаанд гүйцэтгэсэн борлуулалтын орлого аль нэг жилд 30,000,000 төгрөгөөс багагүй байх.</td></tr>
<tr><td>ТӨЗ 1.1 (в)</td><td>Ашигтай ажилласан байх жилийн тоо: Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 оны аль нэг жилд ашигтай ажилласан байна.</td></tr>
<tr><td>ТӨЗ 1.1 (в)</td><td>Тендерт оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадвартайг нотлохын тулд дараах нэмэлт нотлох баримтыг тендерийн хамт ирүүлэх:<br><br>Санхүүгийн тайлан шалгах жилийн тоо: Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 он<br><br>Санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Сангийн яамны мэдээллийн сангаас тендерт оролцогчдын сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онуудын борлуулалтын орлого, шаардлагатай мэдээллийг шалгана.<br><br>Санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулсан байх шаардлагатай эсэх: “шаардлагагүй”.</td></tr>
<tr><td>ТӨЗ 1.1 (г)</td><td>Тендерт оролцогч дараах нэмэлт материалуудыг ирүүлнэ.Үүнд:<br><br>Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэд багтаан ажлыг дуусгаж хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ. Баталгаа гаргаагүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</td></tr>
<tr><td>ТӨЗ 1.1 (г)</td><td>Хийж гүйцэтгэсэн ажлын нийт мөнгөн дүнг жил жилээр харуулсан жагсаалт ирүүлэх шаардлагатай жилийн тоо: Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 он<br><br>
<table>
<tr><th>№</th><th>Гэрээний нэр</th><th>Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо</th><th>Төсөвт өртөг</th><th>Дууссан эсвэл дуусах хугацаа</th></tr>
<tr><td>1</td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td>2</td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td></td><td>Дүн</td><td></td><td></td><td></td></tr>
</table>
</td></tr>
</table>

<table>
<tr>
<td>ТӨЗ 1.1 (д)</td>
<td>
Гэрээг хэрэгжүүлэх удирдах болон инженер, техник, мэргэжилийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл.
Дараах хүснэгтэнд үзүүлсэн удирдах болон инженер техникийн ажилтаныг ажиллуулна.
<table>
<tr><th>№</th><th>Албан тушаал</th><th>Хүний тоо</th><th>Ажилсан жилийн туршлага /мэргэжлээрэ э/</th><th>Мэргэжил</th></tr>
<tr><td>1</td><td>Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер</td><td>1</td><td>1</td><td>Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер</td></tr>
</table>
<ul>
<li>Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер нь тухайн аж ахуйн нэгжид ажилладаг үндсэн ажилтан байх бөгөөд сургууль төгссөн дипломын хуулбарыг ирүүлэх.</li>
<li>Гэрээг хэрэгжүүлэх ажилтаны нийгмийн даатгалын дэвтрийн даатгуулагчийн ажил, албан тушаалын өөрчлөлтийн тэмдэглэл, нийгмийн даатгал төлсөн хэсгийн хуулбарыг ирүүлнэ /нотариатаар баталгаажуулсан байх/.</li>
</ul>
</td>
</tr>
<tr>
<td>ТӨЗ 1.1 (е)</td>
<td>
Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл ирүүлэх жилийн тоо: 2
Сүүлийн 2 жил /2018, 2019 он/-ийн аль нэг жилд ядаж нэг удаа 30,000,000 төгрөгийн өртөгтэй эмнэлэгийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж нийлүүлсэн байх, түүнийг нотлох баримт: Улсын комиссын акт, ажил гүйцэтгэх гэрээ, захиалагч байгууллагын тодорхойлолтын хамт хавсаргана.
<table>
<tr><th>№</th><th>Гэрээний нэр</th><th>Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо</th><th>Төсөв т өртөг</th><th>Дууссан эсвэл дуусах хугацаа</th></tr>
<tr><td>1</td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td>2</td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td></td><td>Дүн</td><td></td><td></td><td></td></tr>
</table>
</td>
</tr>
<tr>
<td>ТӨЗ 1.1 (ё)</td>
<td>Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ форматад хөрвүүлэн, өөрийн аж ахуйн нэгжийн тоон гарын үсгээр цахим хэлбэрээр ирүүлнэ. Тендерт оролцогчийн цахим системээр ирүүлж оролцсон ТӨЗ болон ТШӨХ-д заасан тендерийн баримт бичгийг бэлтгэн ирүүлсэн тендерийн материал нь тендерт оролцогчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн нууц үгтэй улмаас нээгдэхгүй /Adobe PDF/ форматад хөрвүүлсэн файл уншигдахгүй /тод гаргацтай байна/ тохиолдолд үнэлгээнд харгалзан үзэхгүй татгалзах үндэслэл болно.</td>
</tr>
</table>

| | |
|---|---|
| **ТОӨЗ 2.1 (а)** | Захиалагч тендерүүдийг хүлээн авах хаяг нь: Тендер хүлээн авах этгээд:<br>***Тендерийн материалыг Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn) хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (PDF)-ээр илгээнэ. Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100 mb, нэг файлын хэмжээ 15 mb байна. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50'000 /тавин мянган/ төгрөгийг www.tender.gov.mn-ээр банкны меркантийн системийг ашиглан төлнө.*** |
| **ТОӨЗ 2.1 (б)** | Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:<br>Огноо: ***2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр***<br>Цаг: ***10 цаг 00 минут***<br>Тендер хүлээн авах хугацаа нь: ***Цахим худалдан авах ажиллагааны систем ( www.tender.gov.mn )-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй. Тендер хүлээн авах хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.*** |
| **ТОӨЗ 2.1 (в)** | Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:<br>Байгууллагын хаяг: ***Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө, Иргэдэд үйлчлэх төв байр Худалдан авах ажиллагааны алба***<br>Давхар болон өрөөний дугаар: ***9 давхар 902 тоот***<br>Огноо: ***2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр***<br>Цаг: ***10 цаг 30 минут*** |
| **ТОӨЗ 2.3** | ***Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.*** |
| **ТОӨЗ 3.1 (д)** | Уг гэрээг гүйцэтгэхэд тусгай зөвшөөрөл зайлшгүй шаардлагатай эсэх: **Эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх байгууллага нь дараах тусгай зөвшөөрөлтэй байна.**<br><br>***Эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж импортлох, ханган нийлүүлэх, худалдах***<br><br>- Түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгчид нь гүйцэтгэх ажил үүргийнхээ дагуу тусгай зөвшөөрөлтэй байна.<br>- Тусгай зөвшөөрлийн хугацаа нь тендерийн хүчинтэй байх хугацаанд хүчин төгөлдөр байна. Хэрэв тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан бол эрх бүхий байгууллагын хугацааг сунгасан тухай шийдвэрийг ирүүлнэ. |

Гурав. **ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

**1. Барааны тодорхойлолт:**

**ШИНЭЭР БАЙГУУЛАГДСАН ХОРООДЫН ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВД ШААРДЛАГАТАЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ АВАХ АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

2020 оны 01 сарын 14 өдөр Улаанбаатар хот

| Д/д | Барааны нэр, төрөл | Тоо /ширхэг/ | Техникийн үзүүлэлт |
|---|---|---|---|
| 1. | Компьютер иж бүрдэл | 15 | **Дэлгэц 19 инчийн Desktop Mini Tower**<br>**Процессор / CPU**: Intel® 9th Generation Core™ i3-9100 (6M Cache, 4.6 GHz)<br>**Шуурхай санах ой / RAM**: 4GB DDR4 2400MHz (up to 32GB)<br>**Хатуу диск / HDD**: 1TB 7200 rpm SATA 3Gb/s Hard Drive<br>**График карт**: Intel® HD Graphics 630<br>**Оптик драйв**: Tray load DVD Drive (Reads and Writes to DVD/CD)<br>**Сүлжээ**: Integrated Giga bit 10/100/1000 Ethernet<br>**Wireless:** Dell Wireless™ 1707 Card [802.11BGN + Bluetooth 4.0, 2.4 GHz]<br>Dell Multimedia Keyboard-KB216<br>Dell MS116 Wired Mouse Black<br>**Оролт гаралтууд**:<br>**Front**<br>(2) USB 3.0, (1) Universal Audio Jack<br>**Rear**(4) USB 2.0<br>RJ-45, HDMI<br>VGA<br>3-stack audio jacks supporting 5.1 surround sound<br>(2) PCIe x 1, PCIe x 16, PCI (3653 only)<br>**Power Supply Unit:** 290W PSU (EPA Bronze – Full range)<br>**Хэмжээ**:Өндөр: 373мм Гүн: 289мм Өргөн: 160мм Жин: 5.9 кг |
| | Принтер | 1 | **Хэвлэх, хувилах, сканнердах үйлдэлтэй**<br>**Хэвлэлт**: On-demand ink jet (piezoelectric) 4-colour<br>**Хэвлэх нягтрал хамгийн ихдээ**: 5760x1440 dpi (with VSDT<br>**Хэвлэх хурд**: A4 текст (драфт) дунджаар 33/15ppm (хар/өнгөт)<br>Фото (default) - 10x15cm/4x6" дунджаар 69 сек (хүрээтэй)<br>**Хувилах**<br>Үргэлжлүүлэн хувилах: 20<br>Ихэсгэж багасгах: 25-400%, Auto Fit Function<br>**Сканнердах**<br>Нягтрал: 600 dpi x 1,200 dpi<br>Хэмжээ: 216 x 297mm (8.5 x 11.7")<br>Хурд:<br>Дунджаар 11 сек (хар 300dpi) |

| | | | |
|---|---|---|---|
| | | | Дунджаар 28 сек (өнгөт 300dpi)<br>**Хэвлэх цаасны хэмжээ**:A4, A5, A6, B5, 10x15cm(4x6in), 13x18cm(5x7in), 9x13cm(3.5x5in), Letter(8 1/2x11in), Legal(8 1/2x14in), Half Letter(5 1/2x8 1/2in), 13x20cm(5x8in), 20x25cm(8x10in), 16:9 wide size, 100x148mm, Envelopes: #10(4 1/8x9 1/2in), DL(110x220mm), C6(114x162mm)<br>**Орох цаас**: 100/20 хуудас (A4 Plain paper/Premium Glossy Photo Paper)<br>**Гарах цаас**: 30/20 хуудас (A4 Plain paper/Premium Glossy Photo Paper)<br>**Хүрээтэй хэвлэнэ**: Цаасны захаас 3мм<br>**Холболт / Connectivity**: USB 2.0 Hi-Speed<br>**Тохирох үйлдлийн систем**:Windows XP XP Professional x64 Edition / Vista / 7 / 8 / 8.1 Mac OS X 10.6.8, 10.7.x, 10.8.x, 10.9.x<br>**Тохирох хор**:Хар: T00V100 (дунджаар 4,500 хуудас) A4 plain paper Цэнхэр: T00V200 (дунджаар 7,500 хуудас) A4 plain paper Ягаан: T00V300 (дунджаар 7,500 хуудас) A4 plain paper Шар: T00V400 (дунджаар 7,500 хуудас) A4 plain paper<br>**Хэмжээ**: 482 x 300 x 145 мм **Жин**: 3,9 кг **Баталгаа**: 6 сар |
| **2.** | УВЧ шарлагын аппарат | 3 | Өвчин намдаах, булчин суллах, үрэвсэлийн эсрэг эмчилгээнд хэрэглэнэ. Чадал: 30Вт , Хүчдэл: 220ВЦахилгаан тэжээл: 220В /50Гц Давтамж : 27.12±0.16 МГц Гарах чадлийн хэмжээ: 1-р түвшин 10 ± 2 Вт 2-р түвшин 20 ± 4 Вт 3-р түвшин 30 ± 6 Вт Ажиллах цаг: 8 цаг |
| **3.** | Нярайн шарлалт тодорхойлох аппарат | 4 | Нярайн шарлалт хэмжих төхөөрөмж. Овор хэмжээ бага, зөөвөрлөхөд хялбар. |
| **4.** | Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат | 1 | 12 сувагтай, Дэлгэц: 8 инч өнгөт, мэдрэгчтэй LCD 1000 тестийн үр дүнг хадгалах боломжтой |
| **5.** | Ургийн доплер | 3 | Давтамж: 2/3 мГц , Батарей: 1.5V *2. Хэрэглэхэд хялбар, хөнгөн. Тасралтгүй 5 цаг ажиллах хүчин чадалтай |
| **6.** | Отсос цэр соруулах | 1 | Овор хэмжээ бага, ашиглахад хялбар. Зөөвөрлөх боломжтой. Нам даралтын сорох төхөөрөмж. |
| **7.** | Искра | 1 | Мэдрэлийн, булчин, арьс, шүдний системийн зарим нэг өвчлөлийн эмчилгээнд зориулагдсан. Цахилгаан тэжээл : 220В/50Гц<br>Гаргах цахилгаан даралт : 0-3000V<br>хүртэл тохируулж болдог.<br>Цахилгаан давтамж : 50Гц±2Гц<br>Чадал : 600Вт<br>Гаргах цахилгааны урсгалын хэмжээ:6,5мА±10%<br>Цагийн тохируулга : 0-99 минут |

- Ашиглах заавар, гарын авлагыг Өрхийн эрүүл мэндийн төвд хүлээлгэн өгч, акт үйлдэж баримтжуулах.

- Нийлүүлсэн тоног төхөөрөмжүүдийг 72 цаг тасралтгүй ажиллуулан шалгасны дараа хүлээлгэж өгөх.

**Баталгаа:**

- Үйлдвэрлэлийн 1 жилийн баталгааны хуудастай байна.
- Баталгаат хугацаанд цэвэрлэгээ, засвар үйлчилгээг хийх хуваарь ирүүлэх /Багадаа улиралд 1 удаа/

2. **Стандарт:** Нийлүүлэх тоног, төхөөрөмж нь Монгол улсад мөрдөгдөж байгаа болон олон улсын стандартын шаардлагыг бүрэн хангасан, гарал үүсэл, үйлдвэрлэгч нь тодорхой шинэ байна.

3. **Баглаа, боодол:** Нийлүүлэгч барааг эцсийн цэг хүртэл тээвэрлэх явцад эвдрэх гэмтэхээс урьдчилан сэргийлэх баглаа боодлоор хангана.

4. **Бараа хүргэх газар:** Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн Шинээр байгуулагдсан Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд

5. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:** Автомашиныг гэрээ байгуулагдснаас хойш 15 хоногийн дотор нийлүүлнэ.

## БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

| Нэр | Тодорхойлолт | Тоо ширхэг | Хэмжих нэгж | ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг | Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Нийлүүлэх хамгийн эхний хугацаа | Нийлүүлэх эцсийн хугацаа | Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| ***Компьютер иж бүрдэл*** | | ***15*** | ***ширхэг*** | ***Хан-Уул дүүргийн Шинээр байгуулагдсан Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд*** | ***Гэрээ байгуулагдсанаас хойш 15 хоног*** | ***Гэрээ байгуулагдсанаас хойш 30 хоног*** | |
| ***Принтер*** | | ***1*** | ***ширхэг*** | | | | |
| ***УВЧ шарлагын аппарат*** | | ***3*** | ***ширхэг*** | | | | |
| ***Нярайн шарлалт тодорхойлох аппарат*** | | ***4*** | ***ширхэг*** | | | | |
| ***Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат*** | | ***1*** | ***ширхэг*** | | | | |
| ***Ургийн доплер*** | | ***3*** | ***ширхэг*** | | | | |
| ***Отсос цэр соруулах*** | | ***1*** | ***ширхэг*** | | | | |
| ***Искра*** | | ***1*** | ***ширхэг*** | | | | |

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

## 1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

*[огноо]*

***Хан-уул дүүргийн Худалдан авах ажиллагааны алба***-ны дарга ***Т.Улсболд*** танаа

1. Бид, *[тендерт оролцогчийн нэр]* дор дурдсан барааг ***[санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр]*** төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу ***[тоо]*** хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.

2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.

3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

| Нэр төрөл | Тодорхой лолт | Барааны гарал үүслийн улс | Тоо ширхэг | Нэгж үнэ | Нийт дүн | НӨАТ болон бусад албан татвар | Бүгд дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| Тендерийн нийт үнэ | | | | | | | |

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

   Баталгаат засварын хугацаа:

   Санал болгож буй бусад нөхцөл:

   Тендерт оролцогчийн нэр:

   Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

   Албан тушаал, нэр:

   Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ:  ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

| Гэрээний нэр | Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс | Гэрээний үнийн дүн | Гэрээний эхлэх хугацаа | Гэрээний дуусах хугацаа |
|---|---|---|---|---|
| 1. | | | | |
| 2. | | | | |
| 3. | | | | |
| 4. | | | | |
| 5. | | | | |
| бусад. | | | | |

## Тав. **ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ**

| | | |
|---|---|---|
| **1. Шалгах болон турших** | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| **2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт** | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| **3. Оюуны өмчийн эрх** | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| **4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх** | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| **5. Баталгаат засварын хугацаа** | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа ***1*** жил байна. |
| **6. Гэрээнд өөрчлөлт оруулах** | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| **7. Төлбөр** | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш ***ажлын 7 хоног***-ийн дотор шуурхай хийнэ. |
| **8. Бараа нийлүүлэх хуваарь** | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| **9. Алданги оногдуулах** | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| **10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах** | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| **11. Маргааныг шийдвэрлэх** | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

## Зургаа. **ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ**

| | | |
|---|---|---|
| **1. Шалгах болон турших (ГЕН – 1)** | 1.1. | [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.] |
| **2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)** | 2.1. | Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:<br><br>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;<br>2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;<br>3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;<br>4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;<br>5) барааны гарал үүслийн гэрчилгээ.<br><br>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна. |
| **3. Баталгаат засвар (ГЕН-5)** | 3.1. | Баталгаат засварын тусгай шаардлага.<br><br>Нийлүүлэгч автомашиныг хүлээлгэн өгөхдөө авто тээврийн үзлэг оншлогоонд оруулж хүлээлгэн өгнө. |
| **4. Төлбөр (ГЕН – 7)** | 4.1. | Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:<br><br>Гэрээний үнийн дүнгийн ***100*** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө. |
| **5. Алданги оногдуулах (ГЕН - 9)[1]** | ***5.1.*** | Алданги оногдуулах хувь: ***0.5 хувь***<br><br>Алдангийн нийт дүн: ***10 хувь*** |

Долоо. **ГЭРЭЭНИЙ МАЯГТ**[2]

**БАТЛАВ.**

| **ЗАХИАЛАГЧ** | **НИЙЛҮҮЛЭГЧ** |
|---|---|
| ______________________ | ______________________ |
| (Тамга, тэмдэг) | (Тамга, тэмдэг) |
| ______________________ | ______________________ |
| (Гарын үсэг) | (Гарын үсэг) |
| ______________________ | ______________________ |
| (Албан тушаал) | (Албан тушаал) |

***[Тендер шалгаруулалт/гэрээний нэр]* гэрээ.**

Дугаар № *[Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]*

.............................. хот/аймаг

Нэг талаас ***[захиалагчийн нэр]*** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас ***[нийлүүлэгчийн нэр]*** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ___ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь *[гэрээний нэр, дугаар]*-г (цаашид “бараа” гэх) ***[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]*** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг ____________ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, ____________ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, ____________ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

4. Нийлүүлэгч нь ______________________________________________________ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ___-наас _____ оны __ дугаар сарын ___-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

   Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
   Бусад шаардлагатай баримт бичиг[3];
   Үнийн санал;
   Гэрээний тусгай нөхцөл;
   Гэрээний ерөнхий нөхцөл;
   Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
   Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дараалын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.

7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

| **ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:** | **НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:** |
|---|---|
| *[Албан тушаал, нэр]*<br>*[Гарын үсэг]*___________________________ | *[Албан тушаал, нэр]*<br>*[Гарын үсэг]*___________________________ |
| ТАМГА | ТАМГА |
| *[Захиалагчийн хаяг]*<br>*[Утас/факсын дугаар]*<br>*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]* | *[Захиалагчийн хаяг]*<br>*[Утас/факсын дугаар]*<br>*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]* |